



38

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 50

Номгон

Г Аймгийн инженерийн шугам сүлжээ Г
бүхий газрын зөрчилтэй газруудын талаар
авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д ДААЛГАХ нь:

1.1. Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6-д "... 2 жил дараалан ашиглаагүй" гэж заасан үндэслэлээр газар эзэмших эрх нь хүчингүй болгох нөхцөл үүссэн иргэн, аж ахуй нэгж байгууллагын газар эзэмших эрхийг "Ковид-19" цар тахлын нөхцөл байдлыг харгалзан газар эзэмших эрхийг 2 жилийн хугацаатайгаар сунгаж, хариуцлагын гэрээ байгуулсугай.

1.2. Баянхонгор сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт газар эзэмшиж байгаа зарим иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын эзэмшил газарт төрийн байгууллагуудын буруутай шийдвэр, үйл ажиллагаанаас болж гарсан зөрчлийг хууль журамд нийцүүлэн бүрэн арилгаж цаашид зөрчил гаргахгүй байхад анхаарч ажилласугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Норов/-т үүрэг болгосугай.

ДАРГА  Ө.ЭНХБАТ

